БАТЛАВ:
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
..... С.ТӨМӨРДУЛАМ
2022 оны ..05.. сарын ..17..

ХОТЫН СТАНДАРТЫН УДИРДАМЖ АРГА ЗҮЙН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2022 оны ..04.. дугаар сарын ..15..-ны өдөр Улаанбаатар хот

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Баримт бичгийн нэр:	*Авто машин угаалгын газарт тавигдах ерөнхий шаардлага*
Бүлгийн нэр:	• Барилга, бүтээн байгуулалт, хот нийтийн аж ахуйн ажил, үйлчилгээний чанар стандартын баримт бичиг
Ажил гүйцэтгэх хугацаа:	*Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 90 хоног*

ҮНДЭСЛЭЛ:

Хотын стандартын удирдамж, арга зүйн баримт бичиг боловсруулах ажил нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцэх бөгөөд дараах баримт бичгүүдэд тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг болно. Үүнд:

- Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030";
- Засгийн газрын 2016 оны 344 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт "Үндэсний чанарын хөтөлбөр";
- Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.5 дахь заалт "Хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ."

ЗОРИЛГО:

Нийслэлийн хэмжээнд авто машины кузов, явах ангийг угаах ажил үйлчилгээ эрхлэх байгууллага, иргэнд тавих нийтлэг шаардлагын нэгдсэн ойлголт өгөх, мэдлэг олгох, хэм хэмжээг тогтоох хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичиг боловсруулах зорилготой.

ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Стандартын баримт бичиг нь боловсруулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Хууль, дүрэм, журам болон бусад холбогдох стандартыг судлан уялдуулах.
- Авто машин угаалгын газрын гадна, дотор орчин, үйл ажиллагааны стандартын чанарын хяналт ба үнэлгээний ажлын одоо мөрдөгдөж байгаа, шинээр нэмж боловсруулах, шинэчлэх шаардлагатай баримт бичгийг гаргаж, харилцан уялдааг тогтоох;
- Олон улсын чиг хандлага, сайн туршлагыг судалж, газар зүйн ижил төстэй цаг уурын ойролцоо бүсэд орших орнуудын стандарт, норм дүрэм, техникийн баримт бичгүүдээс судалж, оновчтой сонгон өөрийн орны онцлогт тохируулан орчуулан боловсруулах;
- Тухайн баримт бичиг анхаарах зүйлсийг тусган шалгах хуудас боловсруулах;

Хэл найруулгад тавигдах шаардлага:

- Хэл найруулга нь зөв оновчтой байх;
- Нэр томьёоны тайлбартай байх;
- Монгол хэлний зөв бичих дүрмийн болон утга найруулгын алдаагүй байх;
- Тайланг 4 хувь хийж, цаасан болон CD хуулж ирүүлэх;
- Баримт бичгийн эх файл дээр засвар хийх боломжтой байхаар хэвлэлийн эх бэлтгэлийг хийсэн байх;
- Хэвлэлийн шаардлага хангасан өндөр нягтралтай байх;

Баримт бичгийн зурагт тавигдах шаардлага, үзүүлэлтийг оруулах

- Гэрэл зураг нь анхны болон 2 дахь эх үүсвэрээс авсан, өндөр чанартай, гэрлийн бууралтгүй, фокус сайтай байна;
- Бусад эх үүсвэрээс авсан зургийг заавал тайлбар, эшлэл, товч мэдээллийн хамт ашиглана;
- Харагдах байдлын 3 хэмжээст /Render, 3d/ зургийн нягтрал /resolution/ нь 300 dpi, pixels inch -ээс багагүй, JPEG, JPG, PNG өргөтгөлтэй байна;
- Зурган мэдээлэл боловсруулахдаа CMYK өнгөний тохиргоог ашиглана.

ОНЦГОЙ НӨХЦӨЛ

Хотын стандартын баримт бичгийг боловсруулахад дараах нөхцөлийг хангасан байна. Үүнд:

1. Шинэ гарсан технологи, орчин үеийн шаардлага, эрх зүйн баримт бичиг, бусад холбогдох стандарт, норм дүрэм, аюулгүй техник, ажиллагаа, эрүүл ахуйн норматив баримт бичгүүдтэй уялдуулан боловсруулсан байна.
2. Зөвлөх үйлчилгээний үе шатны тайланг “Эрдэм шинжилгээний ажлын тайлан. Бүтэц шаардлага” MNS 2492:2004 стандартын дагуу боловсруулсан байна.

3. Салбарын мэргэжлийн холбоод, төрийн болон төрийн бус байгууллага зэрэг холбогдох байгууллагуудаас албан ёсоор санал авах, саналыг төсөлд хэрхэн тусгасан талаар тайлбар, танилцуулга гаргах.
4. Зөвлөмжийн дагуу шаардлагатай өөрчлөлт, боловсруулалтыг хийнэ.
5. Төслийн хүрээнд боловсруулагдсан, худалдан авч ашигласан бүх цахим болон хэвлэмэл материал, зураг зэргийг эх хувиар эцсийн тайлангийн хамт Захиалагчид хүлээлгэн өгөх.
6. Судалгааны хүрээнд цуглуулсан мэдээлэл, судалгааны үр дүн, тайлан, баримт бичиг нь Зохиогчийн эрхийн тухай хуулийн дагуу Хотын стандарт, хяналтын газрын өмч болно.

Баримт бичигт дараах агуулгыг тусгасан байна. Үүнд:

Д/д	АГУУЛГЫН НЭР	АГУУЛГЫН ХҮРЭЭНД ШААРДЛАГАТАЙ МЭДЭЭЛЭЛ
1	Зорилго	Хаана хүрсэн байхыг илэрхийлсэн томьёоллыг тусгасан байх.
2	Хамрах хүрээ	Баримт бичгийн объект, үйлчлэх хүрээг тодорхойлсон байх.
3	Норматив эшлэл	Эш татсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт, норм дүрэм, журмын жагсаалтыг тусгасан байх.
4	Нэр томьёоны тодорхойлолт	Нэр томьёо, ойлголтын тайлбарыг тусгасан байх.
5	Авто машин угаалгын газарт тавигдах ерөнхий шаардлага	- Авто машины угаалга эрхлэгчдэд тавигдах шаардлага; - Угаалгын төрөл, ангилал - Угаалгын барилга байгууламжид тавигдах шаардлага; - Хүний нөөцөд тавигдах шаардлага; - Судалгааны ажлын үед тогтоогдсон нэмэлт шаардлагатай мэдээллийг нэмж тусгасан байх.
6	Бохир усыг цэвэршүүлэн дахин ашиглах технологийн тоног төхөөрөмж, шаардлага	- Авто машин угаасан бохир усыг цэвэрлэх, зайлуулах, буцааж ашиглах зориулалтын тоног төхөөрөмжийн талаарх мэдээллийг тусгасан байна.
7	Гадна орчинд тавигдах шаардлага	- Гадна талбайн тохижилтыг хэрхэн оновчтой төлөвлөх, байгуулах, ашиглах талаарх мэдээллийг багтаасан байна.
8	Угаалгын технологи	- Угаалга хийх аргыг хэрхэн тодорхойлох; - Гадна болон дотор талыг угаах арга, аргачлал, дараалал; - Угаалгад ашиглах техник технологийн сонголт; - Угаалга, өнгөлгөө, цэвэрлэгээ хийх материалын сонголт, хэмжээ, орцыг тооцох;

		- Угаах хугацааг автомашины төрөл, угаах аргачлалаар тооцох; - Тусгай зориулалтын бодис сонгох, ашиглах аргачлал, техник; - Аюулгүй ажиллагааны зааварчилгаа; - Угаах зориулалттай ажлын байрны температур болон автомашины гадна болон дотор талыг угаах усны температурыг тооцоолох талаарх мэдээллийг багтаасан байх; - Судалгааны ажлын үед тогтоогдсон нэмэлт шаардлагатай арга технологийн мэдээллийг нэмж тусгасан байх.
9	Онцгой шаардлага	Байгаль орчны нөлөөллийн талаарх шаардлагыг тусгасан байна.
10	Анхаарах болон хориглох зүйлс	- Авто машин угаалгын газрын төлөвлөлт, тохижилт, ашиглалтад анхаарах зүйлсийг тодорхой тусгаж, авах арга хэмжээний талаарх мэдээллийг бүрэн багтаасан байх
11	Шалгах хуудас	- Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүхий шалгах хуудас боловсруулсан байх.
12	Ашигласан материалын жагсаалт	Гарын авлагыг боловсруулахад ашигласан эх сурвалжуудын жагсаалтыг агуулсан байх.
13	Зургийн жагсаалт	Боловсруулсан зурган мэдээллийн жагсаалтыг агуулсан байх.
14	Хүснэгтийн жагсаалт	Боловсруулсан хүснэгтэн мэдээллийн жагсаалтыг агуулсан байх.

АЖИЛ ТАЙЛАГНАХ ҮЕ ШАТНЫ ХУВААРЬ

Хотын стандартын баримт бичиг боловсруулах ажлыг дараах үе шаттайгаар гүйцэтгэнэ. Үүнд:

1. Суурь судалгаа хийх, суурь судалгааны тайлан, баримт бичгийн эхний хувилбар боловсруулалт /Гэрээ хийгдсэнээс хойш 21 хоногийн дотор/;
2. Захиалагчийн саналыг тусгасан баримт бичгийн дундын төсөл, хувилбар боловсруулалт /Гэрээ хийгдсэнээс хойш 50 хоногийн дотор/;
   - Холбогдох байгууллагуудаас албан ёсоор авсан саналыг төсөлд хэрхэн тусгасан танилцуулга, тусгасан байдлаарх боловсруулалт /Гэрээ хийгдсэн өдрөөс хойш 70 хоногийн дотор/
3. Баримт бичгийн эцсийн хүлээлгэн өгөх төсөл, хувилбар боловсруулалт /Гэрээ хийгдсэнээс хойш /Гэрээ хийгдсэнээс хойш 90 хоногийн дотор/.

Зөвлөх нь зөвлөх үйлчилгээний хүрээнд эхний, дундын болон эцсийн тайлан боловсруулж захиалагчид хүлээлгэн өгнө. Тайлан өгөх хугацааг ажил эхлэхийн өмнө захиалагчтай зөвшилцөн “Зөвлөхийн ажил гүйцэтгэх төлөвлөгөө” боловсруулж, тайлан өгөх хугацааг тогтоож төлөвлөгөөний дагуу ажиллах бөгөөд тайланд дараах шаардлага тавигдана. Үүнд:

A. Эхний тайлан

Одоогийн байдлын судалгаа, судалгаа дууссан байх, одоогийн байдалд үнэлэлт дүгнэлт хийгдсэн байна.

B. Дундын тайлан

Үндсэн баримт бичгийн эхний хувилбар боловсруулалт - Эхний тайланд өгсөн саналыг тусгаж тавигдах шаардлагын дагуу гүйцэтгэсэн байх, танилцуулга хэлэлцүүлэг хийх /Мэргэжлийн байгууллагуудад танилцуулж хэлэлцүүлэг хийх, санал зөвлөмжийг тусгах/

C. Эцсийн тайлан

Баримт бичгийн эцсийн хүлээлгэн өгөх хувилбар боловсруулалт - Санал, дүгнэлтийг тусгаж, эцсийн байдлаар хүлээлгэн өгөх

ЗӨВЛӨХӨД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Зөвлөх нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Зөвлөх нь Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд аж ахуйн нэгж байгууллага, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага, шаардлага хангасан мэргэжилтнүүдээс бүрдсэн баг байна;
- Гарын авлага, баримт бичиг боловсруулж байсан туршлагатай байх;
- Монгол, Англи хэлний бичгийн өндөр ур чадвартай байх;

ЗӨВЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Зөвлөх багийн гишүүд нь доорх туршлагын доод шалгуурыг хангасан байна. Үүнд:

№	Мэргэжил	Мэргэжил, туршлага
1	Төслийн удирдагч	• Магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх; • Зөвлөх эсхүл мэргэшсэн архитекторын зэрэгтэй байх; • Ижил төстэй төслүүдэд Багийн ахлагчаар ажилласан туршлагатай байна;
2	Салбарын судлаач	• Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний стандарт боловсруулалтын тодорхой сэдвийн хүрээний боловсруулалт хийх чадвартай байх. • Их дээд сургууль төгссөн, ажлын туршлагатай байна. • Судалгаа шинжилгээний болон бодлогын баримт бичиг боловсруулах ажилд оролцож байсан • Төсөл хөтөлбөрт судалгааны ажил хийж байсан. • Аливаа бодлогын баримт бичиг, стандарт боловсруулах арга зүй, ур чадвар, дадлага, туршлагатай байх.
3	Салбарын мэргэжилтэн	• Авто болон механикийн инженерчлэлийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх; • Тухайн мэргэжлээрээ ажилласан ажлын туршлагатай байна. • Аливаа бодлогын баримт бичиг, стандарт боловсруулах арга зүй, ур чадвар, дадлага, туршлагатай байх.

4	Архитектур, дизайнер	• Архитектур, дизайны чиглэлээр их дээд сургууль төгссөн байна. • Тухайн мэргэжлээрээ ажилласан ажлын туршлагатай байна.

ХЯНАСАН:

ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Н.БИЛЭГСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

МЭРГЭЖИЛТЭН П.МӨНХЗАЯА